

**Халх Монголын алдартай Наран хутагт Дэчэн-Одсалбалсамбуугийн
үйлс зохионгуйг товчхон өгүүлэх нь**

Лхасрангийн ТЭРБИШ*
Монгол Улс, Улаанбаатар,
ШУА-ийн Хэл зохиолын
хүрээлэнгийн Сурвалж бичиг,
төвөд судлалын салбар

Received: Jun 11, 2024

Revised: Oct 07, 2024

Accepted: Nov 08, 2024

***Хураангуй:** Наран хутагт нь Энэтхэгт 13, Хачид 1, Төвөдөд 9, Монголд 1, нийт хорин дөрвөн удаа хувилан төрж, шашин амьтны тусыг бүтээгээд хорин тавдугаар төрөлдөө Дэчэн-Одсалбалсамбуу хэмээх алдар олжээ. Тус өгүүлэлд Наран хутагтын эдүгээ төрлийн үесийн хорин долоодугаар болох Наран хутагт Дэчэн-Одсал буюу Төгс цогт амгалан тод гэгээний үйлс зохионгуйг өгүүлэх юм.*

***Түлхүүр үг:** Наран хутагт, Дэчин-Одсалбалсанбуу, хутагт, үйлс зохионгуй*

**A Brief Description of the Khalkha Mongol's Famous Naran Khutagt
Dechen-Odsalbalsambuu's Activities**

TERBISH Lkhasran
*The Sector of the Textology and Tibetan Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia*

1. Удиртгал

Бурхны шашинд байдаг хутагт хувилгаан хэмээх ойлголтыг Үндсэн лам¹⁵⁷ хэмээх сударт: “Бурхан нугууд бээр ариун бус тариалан нугуудад хувилгааныг зохионгуйг орчлон хоосрохуй хүртэл үзүүлнэ” хэмээн

* © Л.Тэрбиш 2024

Email: lterbish@yahoo.com

¹⁵⁷ Үндсэн лам རྒྱལ་ཁོ་མོ། судар нь Ганжуурт буй

зарлигласан, түүгээр үл барам “Мэргэн бүтээлч төрөлхтөн хийгээд, хаан, ноён, харьяат албат гурав, эр, эм гэргийтэн, адаглаад шувуу ба гөрөөс тэргүүтэн амьтан хийгээд, онгоц, гүүр, орон, дэвсгэр, идээ, хувцас, шороо, ус, гал, хий тэргүүтэн сэтгэл үгүй өлгийн байдалтай алин зохистой бээр номхотгогдохуун даяарын ахуй үес ба эцсийн тус амгаланг байгуулан зохионо” хэмээн “Гол модыг байгуулсан судар”¹⁵⁸-т зарлигласан байдаг.

Тэр мэт болбоос дээд төрөлхтний лагшны төрлийн үесийн тоо хийгээд дэс дараа тэргүүтэн миний мэтийн эгэл молхи төрөлхтний оюуны цараас хэтэрсэн зүйл гэлтэй.

Тэр ч хувилгаан хэмээсэн нь мөн чанараараа бурхны гурван лагшны мөн чанартай бөгөөд элдэв дүрсэд хувилж, номхотгогдохууны нигуурт хувь лугаа нь таацуулж ном номлоод, тус амгалангийн үйлсийг зохиохуй нэгнээ таалдаг ажээ. Бурхны гол шүнгийн ёсуудад нийтийн хийгээд нийт бусын таалах ёсон адил үгүй боловч огоот алдаршсан их хөлгөний ёс мэт болбоос өөрийн чанарын хувилгаан¹⁵⁹, амьтныг номхотгохуй хувилгаан¹⁶⁰, элдэв хувилгаан¹⁶¹ хэмээх гурван зүйлээр тодруулаад тэр ч өөрийн чанар хувилгаан хэмээх тэр нь агаарын үзэгдэл төгс эдлэлийн их лагшинт¹⁶² бурхан багш тэр ямагт тунгалаг болроос хөрөг дүрс ургасан мэт язгуурын таван оронд газар олсон их бодисадва нугуудын нигуурт язгуурын таван бурхан хийгээд, амарлингуй эх, догшид хийгээд догшин охины чуулган хэмжээлшгүй үзэгддэг болохоор номыг номлохуй нь өөрийн чанарын хувилгааны ёс оо.

Амьтныг номхотгохуй хувилгаан хэмээх нь аргад мэргэн их өршөөл нигүүлсэл лүгээ төгссөн тэр бурхан бээр бусдын тусад хэмжээлшгүй их тийн цэнгэлгээний ёсоор нэгэн цагт арван зүгийн ертөнцийн аугаа их орон бүхнээ арван хоёр зохионгуйг үзүүлсэн дээд хувилгаан нь бөгөөд тэр тус бүрээр ч өөрийн язгуур лугаа таацсан амьтныг номхотгон чадахуй зургаан зүйлд хувилж, зургаан зүйл амьтан тус бүрийн тусыг бүтээх бөлгөө.

Номт гурван улсын номын хаад, номт мэргэн эрдэмтдийг ч бурхны хувилгаан мөн юм хэмээсэн үзэл номлол нийдэм болсон ажээ. Тухайлбал, Эзэн Чингис тэргүүтэн Монголын хаадыг Очирваань бурхны хувилгаан, Төвөдийн хаадыг Мэлмийгээр болгоогч бурхны хувилгаан, харин Манж Чин улсын хаадыг Манзушир бурхны хувилгаан хэмээн хэлэлцмүй.

Түүгээр үл барам Сажын их бандида Гунгаажанцан (1182-1251)-ыг Манзуширийн хувилгаан, Юань гүрний Хубилай цэцэн хааны ширээний лам,

¹⁵⁸ “Гол модыг байгуулсан судар ལྷོང་པོ་བཀོད་བའི་མདོ” нь Данжуурт буй.

¹⁵⁹ өөрийн чанарын хувилгаан རང་བཞན་སྤྱལ་སྒྲི།

¹⁶⁰ амьтныг номхотгохуй хувилгаан འགྲོ་འདུལ་སྤྱལ་སྒྲི།

¹⁶¹ элдэв хувилгаан ལྷ་ཚྭས་སྤྱལ་སྒྲི།

¹⁶² агаарын үзэгдэл төгс эдлэлийн их лагшинт དབྱིངས་རྣང་ལོངས་སྤྱུ་ཆེན་པོ།

улсын багш Догон Пагба Лодойжанцан (1235-1280)-ыг Очирваань бурхны хувилгаан хэмээн үзэх жишээтэй.

Бурхны шашны номын ёсноо авшиг, эш, хөтөлбөр гурав хийгээд увдис сэлтээр өөртөө дагуулан эзэлсэн тэр ламыг бодитой бурхны хуран мэдлээр барих хэрэгтэй хэмээн номлоод, тэр тоолшгүй олон амьтны зовлонг болгоон санасаар төрөл таалсан хувилгаан бодгаль мөн хэмээн тодруулах журам ёс буй ч өөрийнхөө ачит ламыг үргэлж тасралтгүй дахин дахин төрөл таалсан хувилгааныг тодруулан үйлдэх тэр ёсыг анх Төвөдийн Их шидтэн Үржинба бээр нээсэн билээ. Өөрөөр хэлбэл анх хувилгаан дүрийг тодруулсан хүмүүн бол Үржинба юм. Энэ тухай эх бичигт хэрхэн дурдсаныг сонирхохул:

Цүрпүгийн хурлын газрын ширээт Их шидтэн Гарма багш хэмээн алдаршсан таалал болохдоо мэргэн, бүтээл хоёр төгссөн олон шавь буйн дотроос Их шидтэн Үржинг хийдийн ширээтэд тушаагаад,

“Онол төгс егзөр Өөрөө гарсан очир¹⁶³ би

Орой наран шингээд маргааш ургах мэт

Олон шавийн үйлд нийцүүлэн хувиран төрнө”

хэмээсэн ба “Дод нутгаас¹⁶⁴ Хар малгайт¹⁶⁵-ын үндсийг баригч нэгэн наран ирнэ. Тэр болтол Ялгуусны орыг барьтугай!” хэмээх тэргүүтэн хувилгаан төрөл өөд болон морилохуй тухай эш бошгийг дахин дахин зарлиглаад, алтан отго жинстэй хар малгайг Үржингийн тэргүүнд асааж, хийд орны ширээг тэтгэн суух хэрэгтэй эш бошгийг соёрхов. Их шидтэн бээр ламынхаа зарлигчлан хийдийн газрыг тэтгэн суухуй тэр цагт Ман орны Гүнтан Ганшүрмо¹⁶⁶ хэмээхийн хөвөөнөө Омалүнхан Танза Пүлүншод¹⁶⁷ хэмээх нутагт V жарны модон бичин жил (1284) эцэг Их тарнич Чойбал хийгээд эх Жомо Яндэн хэмээгч шавраар гар урлал хийж амь зуудаг нэгэн өрхийн гэрт эснэсэн ба олон сонин гайхамшигтай бэлгэ совин хийгээд зүүд болсон хэмээн нутгийн хүмүүс хэлэлцдэг. Хоёр гурван сүүдэртэйдээ өмнө, хойд төрөл ба ирээдүй цагт болох эш бошгийг гэнэт зарлигласан бээр бусад лугаа адил үгүй нэгэн хөвгүүн байна аа хэмээн мэдэцгээжээ.

Өмнө хэлсэнчлэн хутагт хувилгаад нь олонх тохиолдолд эцэг эхдээ онцгой сонин бэлгэ совин үүсгэн эснэдэг бөгөөд нялх бага насандаа урьд төрлийн хэрэг явдлаа дурдан мэддэг байна. Тухайлбал, Монголын алдартай хутагт хувилгаадын нэгэн Халхын ламын гэгээн Ханчэн Чойжилын анхдугаар дүр Лувсанданзанжанцан нь Батмөнх даян хааны аравдугаар хөвгүүн Жалайр

¹⁶³ Өөрөө гарсан очир འག་བླ་མ་ལྟོ་ལྟོ།

¹⁶⁴ Дод нутгаас ལྷོ་ལྷོ།

¹⁶⁵ Хар малгайт ལྷོ་ལྷོ།

¹⁶⁶ Ман орны Гүнтан Ганшүрмо མང་ལྷོ་ལྷོ་མང་ལྷོ་ལྷོ།

¹⁶⁷ Омалүнхан Танза Пүлүншод འོ་མ་ལྷོ་ལྷོ་མང་ལྷོ་ལྷོ།

хун тайжийн ач хөвгүүн болж, XI жарны “Согтох төгөлдөр” хэмээх шороон туулай жил (1639)-ийн Монголын тооллын анхдугаар Мэг сарын арван дөрөвний өдрийн үдэш, арван тавны эдэлбэрт ээлжийн гараг Сугар, саран од Мэг одны анхдугаар мөчид лагшин мэндэлбэй. Арван гуравны шөнө эцэг нь нэг цагаан шонхор шувууны зулзагыг хөлөөс нь хэв торгоор уяж, гэрийн тоононы дээр тэжээж буй хэмээн зүүдэлсэн ажээ. Дөрвөн сүүдэртэй байхдаа эхийнхээ мээмийг хөхөн ахуйд дэргэд нь өөр нэгэн хүмүүн бээр Очир Аюулгагчийн ерөөлийг уншин ахуй үест Ариун бэлгэ билгийн орд харшийг бүтээтүгэй!¹⁶⁸ хэмээсний арынх нь үг нь санаанд нь оролгүй удаан самгардан удаан давтан байхын үест энэ Богд тэргүүнээ өргөөд, Алин түүнд нь гүргэм Сүмбэр уулыг давхарласан мэт¹⁶⁹ хэмээн зарлиглаж, тэргүүнээ эхийн өвөр дээр тавьсан нь онц гайхамшгийг төрүүлсэн хэмээн асрагч эх нь өгүүлж байсан ажээ. (Лувсанпэрэнлэй, 1486)

Энэ мэтээр хувилан төрсөн хувилгаадыг тэр цагийн нэр нөлөө бүхий ихэс лам нар тодруулан баталгаажуулах ёс журам ч тогтжээ. Тухайлбал, Богд Зонхавын үүтгэсэн Шар малгайтны шашны удирдагч Далай лам, Банчин богд нар өөр зуураа алин түрүүлж төрсөн нь нөгөөхөө тодруулдаг, тэд бас Халхын нэр нөлөө бүхий хутагт хувилгаадыг тодруулдаг байх жишээтэй. Чингэж тодруулахдаа бэлгэ үзэх, гүртэн буулгах, Төвөдөд бол зарим тохиолдолд III Далай лам Содномжамц (1543-1558)-ын нээсэн Лхамын луст нуур буюу Тэнгэр нуурт хүрч, нуурын бэлгэ тэмдгээр хувилгаан дүрийг тодруулдаг байна. Манж Чин улсын үед Далай лам, Банчин богд нарын тодруулсан хувилгаан дүрийг эзэн хааны нийслэл Бээжин хотын Юнхэгүн хийдэд хумхаас шаваг татаж баталгаажуулдаг болсон байна. Энэ нь Ханчин номын хааны хоёрдугаар дүр Лувсанванчинбалбарын хойд дүрийг тодруулахдаа Шанзав Агваандаш хэмээгч Жамбалжамц¹⁷⁰ -ын айлдсанаар Ламо чойжингоор гүртэн буулгуулж, тодруулахдаа түүнд хээл хахууль өгч, Түшээт хаан Цэдэндоржийн хөвгүүнийг хуурамчаар тодруулсан нь Манж эзэн хааны сонорт хүрч, хуурамч дүр болохыг илрүүлж, Тавнан Дармын хөвгүүн Цэвээнжавчогбалсамбууг өмнөх аргаар Лувсанванчинбалбарын хувилгаан хэмээн бататган тодруулсан үеэс эхэлсэн ажээ. (Тэрбиш, 2024: 47-71)

Ер нь тодорсон аль ч хувилгааны төрлийг урагш нь хөөхөд Бурхан багш буюу түүний үеийн бодисадва нар дээр тулж очдог ажээ.

¹⁶⁸ Ариун бэлгэ билгийн орд харшийг бүтээтүгэй! མཁན་དག་ཡི་ཤེས་གཞུང་ཡས་ཁང་འབྲུབ་ཤིག།

¹⁶⁹ Алин түүнд нь гүргэм Сүмбэр уулыг давхарласан мэт ཇེར་ནི་ཀྱང་གུམ་ལྷན་པོ་བརྟེན་པ་བཞིན།

¹⁷⁰ Хамгийг айлдагч ялгуусны эрхт Жамбалжамц нь Далай ламын лагшны VIII эрх Ялгуусан Жамбалжамц འཇམ་དབལ་བླ་མ་ཚྭ། (1758-1804 он).

2. Судалгааны хэсэг

Наран хутагт нь хорин дөрвөн удаа хувилан төрж, шашин амьтны тусыг бүтээгээд хорин тавдугаар төрөлдөө Дэчэн-Одсалбалсамбуу хэмээх алдар олжээ.

Түүний өмнөх хорин дөрвөн дүр нь:

1. Насад охилогч *вун-хув-сэсэс-дсид-хув-хув*
2. Сайваар ажирсан маш тод *вде-хув-хув-сэсэс-хув-хув*
3. Индравүди хаан *хув-хув-хув-хув-хув*
4. Итгэл Их амгалан *хув-хув-хув-хув-хув*
5. Хиргүй төгс цогт лам *хув-хув-хув-хув-хув*
6. Маш баясгалант очир *хув-хув-хув-хув-хув*
7. Ловон Цагаан лянхуа *хув-хув-хув-хув-хув*
8. Их шидтэн Лү-иба *хув-хув-хув-хув-хув*
9. Вирвава *хув-хув-хув-хув-хув*
10. Бат агч Вира *хув-хув-хув-хув-хув* буюу Сатавира *хув-хув-хув-хув-хув*
11. Дармабала хаан *хув-хув-хув-хув-хув*
12. Гаяадара *хув-хув-хув-хув-хув* буюу Их бандида *хув-хув-хув-хув-хув* Үүлэн баригч *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
13. Их шидтэн Дүвүва *хув-хув-хув-хув-хув*
14. Хачийн их бандида Шагьяа *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
15. Хотлыг айлдагч Сэрэн дэлгэрсэн багш *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
16. Хотлыг айлдагч Номын лагшинт гэрэл *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
17. Хамгийг айлдагч Хөвгүүн багш Их эрдэнэ бүтсэн *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
18. Ярлунгийн Сэнгэжанцан *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
19. Буяны сайнхүү *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
20. Жавзан Налжир Баатар *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
21. Царчин Очирдарь *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
22. Ганжуурч Итгэл дээд буян төгс *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
23. Хувилгаан Буяны номын наран *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*
24. Сэрэн дэлгэрсэн гэгээнээ алдаршсан *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув* *хув-хув-хув-хув-хув*

нар бөгөөд Энэтхэгт 13, Хачид 1, Төвөдөд 9, Монголд 1 эснэсэн байна. Наран хутагтын эснэсэн төрлийн үесийг “Заяын Сан-ег”-г:

“Номлох, маргах, туурвих гурван хүрдийг мэргэн, ариун, сайн гурвын үүднээс ялгуусны шашин нийт хийгээд нэн ялангуяа ханьцаш үгүй шар

малгайтны шашин их эрдэнийг хойт зүгт өдөр мэт тодруулан зохиосон энэ Их дээд төрөлхтөн ямагтын агь шавийн дараалал нь Донхор хувилгаан Жамбалсамбуу¹⁷¹, Жалханзийн хувилгаан Лувсанданзан¹⁷², Мэргэн номун хааны хувилгаан Равдан, Чойжав дияанч хувилгаан, Ордос Шавран хувилгаан, Шарзэ хувилгаан¹⁷³, Бүтсэн хувилгаан¹⁷⁴, Дарба бандида цорж¹⁷⁵, Тойсамлин хийдийн гэгээн Лэгшадбалдангийн хувилгаан, Зэнмэни мэргэн цорж, Мэргэн бандида ранжамба Лувсанринчэн, Бандида лам Лувсанжамц, аграмба цорж Чойжанцан, Дархан цорж, Номч цорж, Наран хутагт¹⁷⁶, Жанцан хувилгаан, Лам егүзэр хувилгаан, Эрдэнэ цорж, Үй, Зан ноён хувилгаан, Унзад Лувсанравдан, Унзад Дагважанцан, Ням, Дагва эмч тэргүүтэн хийгээд Очир Түшээт хан, Жамба дайчин ван, Мэргэн ван, Даёо хунтайж¹⁷⁷, Хөндлөн ван, Сидири баатар хунтайж¹⁷⁸ тэргүүтэн их, бага олон ноёд болон би тэргүүтэн шарын язгуурт дээд, доод лам, хар нар, дээдийн номын рашаанаар чухал тэжээгдсэн шавь нарын язгуур ч тэнгэрийн од лугаа тэнцэх маш олон буй” (Лувсанпэрэнлэй, 1486)

хэмээсний дотор гарч буй Наран хутагт нь Наран хутагтын төрлийн үесийн хорин гуравдугаар хувилгаан Содномчойжиням юм.

Тэр бээр эрт ловон Бадамжунай бээр зэс өнгөт Цогт уулнаа залран саатахуй цагт адистидалсан Ман орны Гүнтанд¹⁷⁹ лагшин эснэж, төрсөн даруйгаасаа ловон Бадамд залбирал талбин, ёгыг онцгойлон авчээ. Нялх бага цагтаа Төгс цогт Сажтаны хийдэд хүрч, лам Сүрчэн Чойенрандол¹⁸⁰-ын өлмийн тоосыг тэргүүгээрээ аваад, таалал нь баясан үйлдсэн бээр Цогт Загарсамбар Хэрүгагийн авшиг өргөв. Дандрын номлол, увдис соёрхов. Тэр цагт лам, ядам бурхныг бодитой үзэн болгоов. Тэгээд ламын өлмий бататгал үйлдсэн бээр өнө удалгүй ламын зарлигчлан Цогт Загарсамбарын лагшны орон их цаст уул Дисиг тэргүүтэн уулын зав нугуудад шарид бүтээл зохиосон бээр үйлсийн цагт буусныг таалан болгоогоод, Халхын энэ орныг бойвоор тамгалан зохиосон байна. Түгээмлийн эзэн хүрдний итгэл цогт Доржсэмбаа хойд зүгийн Халхын заяат бурханд ургасан Жавзандамба Лувсанданбижанцанбалсамбуу, Зая

¹⁷¹ Донхор хувилгаан Жамбалсамбуу ལྷོང་འཁོར་ལྷུ་སྐུ་འཇམ་དཔལ་བཟང་པོ།

¹⁷² Жалханзийн хувилгаан Лувсанданзан ལྷུ་ཁང་ཆེན་ལྷུ་སྐུ་བཟང་བཟན་འཛིན།

¹⁷³ Шарзэ хувилгаан ཤར་ཅེ་རྒྱུ།

¹⁷⁴ Бүтсэн хувилгаан བུ་བྱལ་ལེན་རྒྱུ།

¹⁷⁵ Дарба бандида цорж འདར་པ་བརྩེ་ཏུ་ཆོས་ཤི།

¹⁷⁶ Наран хутагт ན་རང་ཁྱ་ཐུག།

¹⁷⁷ Даёо хунтайж ཇ་ཡོ་ཨོང་ཐའི་ཇི།

¹⁷⁸ Сидири баатар хунтайж སིདྲི་བྱི་པ་ཐུར་ཨོང་ཐའི་ཇི།

¹⁷⁹ Ман орны Гүнтан མང་ཡུལ་རྒྱུང་ཐང་།

¹⁸⁰ Сүрчэн Чойенрандол ལུར་ཆེན་ཆོས་དབྱིངས་རང་གྲོལ།

хотол явдлын үндэс”¹⁸⁹, “Нууцын бүтээл”¹⁹⁰ тэргүүтэн бүтээлийн зүрхний гол судар нугуудыг цээжээр зарлиглаад, тэдгээр шүнгийн утга алин гарсан бүгдийн магад утгын лам, амгалан, хоосон ялгал үгүй бэлгэ билиг нэгний дүр байдал ямагтад үзүүлсэн мөн хэмээн дахин дахин зарлиглав. Аяга тахимлаг Лувсан тэргүүтэн зарим нэгэн сүсэглэж байсанд нэгэн өдөр шашин өрнөн дэлгэрэхийн ерөөлийг аугаа ихэд зохиожухуй. Хоёр мутраа хонх, дамар лугаа сэлт тэгш агуулаад, сонин гайхамшигтай олон үзэгдэл совин лугаа сэлт ажирсан болой. (Наран хутагтын цадиг, 246-25а)

Эдүгээ төрлийн үесийн хорин долоодугаар болох Наран хутагт Дэчэн-Одсал¹⁹¹ буюу Төгс цогт амгалан тод гэгээний зохионгуйг өгүүлсү!

Өмнө өгүүлсэнчлэн тэр бээр Гүн Равдандоржийн хошуунд Их Зэсийн цахир толгой¹⁹² хэмээх газар эцэг Ундрахад “Огторгуйгаас таван үзүүртэй нэгэн очир буугаад гэрт нь орж ирэн өнхөрч байна”, Эх Долгортгоо Нарны хот мандал оройд нь суугаад, зүрхэн тус газар гэрэл гялалзан гялалзан ургав” хэмээх зүүд мануулсаар XIV жарны усан гахай жил (1863)-ийн Монголын тооллын гуравдугаар сарын шинийн наймны өдөр нар мандсан даруйд лагшин нь цагаан салиагаар бүрэгдсэн, дээд лагшныг хүйс нь ороосон, сүрээр эс дарагдам нарны хурц цагаан гэрлийн цогц тойруулаад эснэсэн ажээ. Эцэг Ундрах нь ноён нуруу сайтай, дээдсийн явдал лугаа төгс бөгөөд харин эх Долгор нь эхнэр хүмүүний сайн бэлгэ төгссөн нэгэн бөгөөд тэд өмнийн дүрд нь харилтгүй сүсэг төгссөн мөний тул “Тэр лам бээр авартугай!” хэмээж, Ламжав¹⁹³ хэмээхүй нэр өгвэй. Эцэг эх нь онцгой содон энэ хөвгүүнийг эгэл бус нэгэн хэмээн магадлан мэдээд, энхрийлэн цэвэрхнээр өсгөн тэжээжээ. Хөвгүүн өсөн торнисон ч хэл эс орсон тул “Энэ хөвгүүн хэлгүй юм болов уу?” хэмээн сэжиглэн зовнин сууцгаахад, лагшин сүүдэр гурвыг зооглосон жил (1865)-ийн рид хувилгаан сарын шинийн нэгний өдөр “Ламдаа залбирал одуулмуй” хэмээн гэнэт тод тодорхой зарлиглаж хэлний үүдээ нээж, гэрт нь Бурхан багш Чадагчийн эрхтийн нэгэн хөрөг байсныг “Энэ миний лам мөн” хэмээн зарлиглаж, мөргөл, тахилыг үргэлжид зохиох болжээ.

Тоглон наадан зохиохуй үест ч бусад хүүхдүүд лүгээ адил үгүй, дуган сүм барих, шүтээн байгуулах тэргүүтний дүр маяг ба тоглодог газар ширээ мэт нэгэн хад буйн дээр очиж, бойвоор завилан лагшнаа цэхлэн залж, ном номлохуй хийгээд тэгш агуулахуй дүр байдлыг үзүүлдэг, бас заримдаа “Зэсийн өнгөт

¹⁸⁹ Егээр эх хотол явдлын үндэс ནལ་འབྱོར་མ་ཀུན་ཏུ་བྱོད་པའི་བླ་

¹⁹⁰ Нууцын бүтээл གསང་བ་བྱུང་བ།

¹⁹¹ Дэчэн-Одсал བདེ་ཆེན་འོད་གསལ།

¹⁹² Их Зэсийн цахир толгой མི་ལེ་ཇོ་ལའི་ཆ་ལིང་ཐོལ་ཀལ།

¹⁹³ Ламжав ལྷ་མ་བླུངས།

Цогт уулын Бадамжунай тэр миний язгуурын бурхан мөн” хэмээн хатуу хүчтэй залбирал талбих тэргүүтэн дээдсийн ахуй ёс үзүүлдэг байжээ.

Тэр хөвгүүний эцгийн ах аяга тахимлаг Лувсанцүлтим хэмээгдэх нэгэн өмнө Санжаананвадагба нөгчихүй үест чилээг нь сувилж байхдаа “Лам их эрдэнэ ээ. Юутай ч нөгчихүйг таалах болбоос хойд төрөлдөө миний шадар төрлийн гэр бүлд эснэж, биднийгээ дагуулан эзлэх хэрэгтэй байна аа” хэмээн их шамдлаар айлтгахад нь “Тэр мэт шаардлага боловсруулах болбоос харилтгүй сүсэг бишрэлээр залбирал талбитугай! Магадтайяа яван, эргэн ирэх буй” хэмээн гэгээнээр сайтар таалсан буйг дурсаад, өмнийн тэр зарлигийг сэтгэлдээ хадаж, “Лам эрдэнийн зарлигийг үлэн бодвоос энэ өчүүхэн хөвгүүн ламын хувилгаан байж ч мэднэ. Биш ч гэсэн ламын хувилгаан төрөл хаана төрсөн буйг эрэх хэрэгтэй тул дээд төрөлхтөн нүгүүдэд айлтгах хэрэгтэй!” хэмээн сэтгэж, Төвөдийн Зангийн зүгийн Дашлхүмбэд хөлгийн жолоо залав. Хамгийг айлдагч Банчин богдод мөнгөн мандал нэг, хос билар¹⁹⁴, хос чөмгөн бүрээ сэлтийг өргөж, “Миний лам Наран хутагт хэмээгч нөгчсөний хувилгаан дүр эдүгээ хаана эснэсэн буйг тодруулсан эш бошиг соёрхон айлд аа!” хэмээн залбирал талбисан бээр Дээд аврал итгэлийн гэгээнээс: “Зуу эрдэнэ лагшин хөрөг нэгнийг бүтээ! Тэр ламын хувилгаан чиний төрлийн гэрт эснэсэн нь чиний дэргэд байна. Түүнд Дэчэн-Одсал хэмээх нэр өг! Энэ эрихийг өргө!” хэмээн зарлиглаж, мутрынхаа нэгэн эрхийг хайрласан бээр хэмжээлшгүй их баярласан ажээ.

Жич тэр аяга тахимлаг бээр Гүмбүм Жамбалинд хүлгийн жолоо залав. Гүмбүмийн ширээт хийгээд Гүмбүмийн номын сахиулсан хоёрт Дээд Банчин эрдэнийн тэр эш бошгийг өчүүхэн төдий ч эс дурдан, “Ламын хувилгааныг шинжлэн хайрла!” хэмээн айлтгахад нь тэр хоёулаа ч “Чиний ач бэлгэ тэмдэг сайтай нэгэн буй. Тэр чиний ламын хувилгаан эндүүрэггүй мөн” хэмээн зарлигласан бээр сэтгэл батад итгэмжлэхүй нэгнийг олов. Бас тэр цагт эчнээ эш бошиг үзүүлэгч Ажаа хутагт эрх хүчтэй үес мөний тул түүнээс ч ламын төрлийг шинжлүүлэхээр айлтгахад, “Чиний дэргэд сэжиглэгдэн сууж буй өчүүхэн хөвгүүн нэгэн буй. Тэр мөн” хэмээсэн мутрын улаан тамгатай зарлиг бичиг, зангиа сэлтийг хайрлав. “Зөөлөн цогтын алдрыг өгүүлэхүй”-г гэгээнээр уншин зохиож, Алдар их, яруу алдар их бөгөөд; их гэгээн тодорхой их¹⁹⁵ хэмээхийн үест мутраар тамгалж, хайрласан бээр тэр аяга тахимлагийн сэтгэлд ийн хэмээн ургажухуй “Оюун төгс анхны үсэгт эх”¹⁹⁶ хэмээсэн бээр “Богд ринбүүчийн эш бошиг үзүүлсэн мэт номлосон даруйд нэг, хоёрдугаар мөрөөр Наран хутагт хэмээн эш бошиг үзүүлсэн буюу эцгээр айлдаж, энэ мэт дохио зохиосон байна”

¹⁹⁴ билар - үлээх этгээд нь бишгүүр мэт доорд тал зэс бүрээний адил

¹⁹⁵ Алдар их, яруу алдар их གཤམ་ཆེན་ལྷན་གཤམ་ཆེན་པོ་ལྷུ་; их гэгээн тодорхой их ལྷན་པ་ཆེན་པོ་གསལ་བ་ཆེ

¹⁹⁶ Оюун төгс анхны үсэгт эх ལྷན་པ་ཆེན་པོ་ལྷུ་གཤམ་

хэмээн сэтгэсэн ба бус бас, урьд төрлийн алдар ба, Аврал итгэл дээд бээр соёрхсон алдар ба, Ажаа хутагтын энэ зарлиг хийгээд, ачийн эснэсэн нутгийн нэр ба төрөх цагт гэрэл хүрээлсэн хийгээд Гүмбүмийн ширээт ба Номын сахиулсан хоёрын эш бошиг ба, өмнө нөгчсөн төрлийн зарлиг нугуудыг өөр зуур нь таацуулж, алины талаас ч нийцэн одсон бээр “Шалгадаг төрөлхтөнд эндүүрэг эс эрхшээмүй” хэмээсэн дээдсийн үзэл бодол адилхан байна аа” хэмээсэн бат баяслыг олжухуй.

Тэгээд тэр аяга тахимлаг нутагтаа хүрч, учир шалтгаан хийгээд тэдгээр эш бошгийг дүү Ундрах тэргүүтэн гэр бүлийнхэнд өгүүлсэн бээр зэргэмжээр тархаж, нутгийн хүмүүс “Энэ хөвгүүн Наран хувилгаан хэмээгч тэр мөн” хэмээн дуурьсгаж, мутрын авшиг айлтгагч нар ч олон гарав. Тэр үест тэр хөвгүүн бээр үсэг унших тэргүүтнийг эс айлдан мэддэг ч ялгуусан Вэнсагийн намтрын нэгэн судар буйг болгоож, “Төгс буянтны шашны амин зүрхэн Жавзан Вэнсагийн чихний дамжлагын сонин гайхамшигтай увдис үүнийг эрхшээсэн лам хэн байна аа?” хэмээн тойд бүхнээс асуухуйд, бүгдээр “Энэ хөвгүүний хэлсэн зүйл барилдлага ихтэй, харваас энэ ном тэр мэт нэгэн буй нь магадлалтай боловч үзэж, сонсон мэдээгүй тул эс мэдмүй” хэмээлдэхэд, Лувсанбалбар хэмээгч нэгэн лам бээр “Банчин богдын бодитой шавь Бигэр номон хаан хэмээгч лам Төгс буянтны шашныг огоот эрхшээсэн болохоор тэр ламд гэгээн золгон айлтгахуйд хэмжээлшгүй дуршин, цангасан төрөлхтөн ус хүсэхүй мэт сэтгэл эснэсэн ч лагшин нь маш бага тул гэгээн золгохыг айлтгаж эс чадав.

Бас нэгэн аяга тахимлагийн судрыг үзэн болгоож өмнө төрлийн нь мутрын судар Банчин Лувсанчойнжины сүмбүмийн нэгэн бүлэг байсныг олж мэдээд, “Энэ миний ном байна. Надад өгөх хэрэгтэй” хэмээн зарлиглахад нь тэр бээр “Чиний ном мөн нь мөн өө” хэмээн баясаж өргөжээ. (Наран хутагтын цадиг, 256-27а)

Чингээд лагшин сүүдэр наймтайдаа авга аяга тахимлаг Лувсанцүлтимээс огоот төгссөн увшийн санваар таалж, Банчин эрдэнэ өмнө нь хайрласан Дэчэн-Одсал хэмээх алдрыг өргөв. Баажүү шавран ринбүүчи¹⁹⁷-ээс “Огторгуйн үүд нээгч”¹⁹⁸-ийн авшиг сонсов. Аяга тахимлаг Лувсанданзаны дэргэдээс га, ха тэргүүтэн үсэгт суралцан, харсан төдийхнөөр айлдан мэдэв.

Хувилгаан Лувсанданзаны дэргэдээс сэтгэл үүсгэхийн зан үйлийг бариад ялгуусны агь суралцагчийн сүргийн манлай болов. Хаянхярваагийн авшиг, даган соёрхол сонсов. Заримдаа урьд төрлийн үесийн их шидтэнүүдийн онол өөрөө эснэхүй илт болсон бээр төр ёсны явдалд оршихуйг болгоож, хутга лугаа

¹⁹⁷ Баажүү шавран ринбүүчи བཤུ་ཁབ་བྱང་ཆེན་པོ་ནི་ Гүмбүм хийдийн хамба бөгөөд, сул хамба болоод, Засагт хаан аймгийн нутгаар саатан морилж, олон хийд оронд ном дэлгэрүүлэн, чамгүй олон хийд орон тогтоосон билээ.

¹⁹⁸ Огторгуйн үүд нээгч རྒྱ་མཐོང་གི་ཕྱོད་ཀྱི་

хөдлөхүй очир²⁰⁹, Самбар Лү-Иба²¹⁰, Очир Аюулгагч арван гурван бурхант нугуудын авшиг сонсов.

Товчилбоос, алдарт дээдэс нүгүүд хийгээд хувилгаан тэргүүтэн арван орныг айлдагч буяны багш садан, тогтсон таалал алагчлал үгүй, эш ба онол даяарт мэргэжсэн дөч гаруй багшийг оройн чимэгт шүтэж, зарлиг хийгээд тааллын тайлбараар хураангуйлсан сайн зарлиг бүхнийг хүү сандаа эс агуулснуудыг олж авсан ажээ.

Өмнө нь Төв үзлийн ангид орохуй үед “Хамба Лүнриг Дандаржанцанбалсамбуугийн дэргэдээс олсон ялгуусан Вэнсагийн энэ увдисыг олж, алмайрлын мөрд хүмүүний насыг барваас гэмшил их мөний тул Их шидтэн Чойдоржийн суухуй орон Жомо Лха ри²¹¹-д хүрч, ялгамжтай тэр орноо бясалгал бүтээлийг дагнан үйлдээд, үр нь ямар мэт болохыг үзэх хэрэгтэй” хэмээн сэтгэж, Лувсангийн гаабумаас өвөрт багтахуй хэмжээтэй жижиг дэвтэр сийрүүлэн салгаж, Авга лам ринбүүчи Лувсанцүлтим гуайгаас явах хэргийн талаар айлтгахад нь түүний гэгээнээс: “Чи Төвөдөд явах болбоос амь насанд чинь тогтор ихтэй тул явах хэрэггүй. Чиний өмнөх төрөл хойд насандаа хийдийн аймаг тогтоох ба бурсан хуврагийн аймгийг шинээр тогтоох учир шалтгаантай” хэмээн дахин давтан зарлигласан хийгээд, “Үй, Зан, Амдуу газрын бэлгэ билгийн мэлмий төгссөн нүгүүд бээр ч чиний энэ насны үест хурлын аймаг ба Бурсан хуврагийн аймаг тогтооно хэмээн эш бошиг үзүүлсэн нь олон буй тул билгээр үйлдтүгэй!” хэмээн зарлигласан бээр явахаа хойшлуулсан ажээ.

Тэгээд лагшин сүүдэр гучийг зооглосон жил (1892) Их Хүрэнээс өөрийн нутгийн зүг залрав. Ноён гүн Равдандорж ба Хошууч бэйс Насанжаргал хоёрт “Та хоёр бээр эрхшээсэн газар орны хаяа хөдөрсөн зааг Сангийн далай хэмээх нуурын хойд талд өмнийн дээдэс төрөлхтөн нүгүүдийн өлмий батдахуй ба шашинд дэмжлэг болгохын тулд суралцагч сэлтийн өргөлд хүндлэлийг бүтээхийн тулд нэгэн хурлын аймгийг шинээр тогтоохыг хүсвээс тэр газар орныг соёрхох хэрэгтэй” хэмээн сонорын хуурцагт айлтгасан бээр тэр хоёул ч шашин, төрд туслахуй цаг болсныг анхааран эрхшээсэн бээр “Тийм болбоос дээд төрөлхтөн таны алин таалсанчлан зохиотугай! Бид ч даган баясахуй болой” хэмээлдэж, ихэд баяссаар газар орныг өргөв.

Тэр усан луу жил (1892)-ийн өвлийн дунд сарын шинийн арван зургааны өдөр *шадарч сэлттэйгээр их нуурын хойд талд залраад*, хоноглон зохиосон тэр шөнө, тэр газар оронд маш цагаан гэрэл гялбалзан гарч айл амьтан нугууд бээр хараад, “Тэр тод гэрэл ямар учиртай юм бол оо” хэмээцгээсэн гэдэг. Арван

²⁰⁹ Нууцын хураангуй Үл хөдлөхүй очир གསང་འདུས་མི་བསྐྱོད་ནི་རྒྱུ།

²¹⁰ Самбар Лү-Иба བདེ་མཚན་ལུ་ཇུ་ཨ་བ།

²¹¹ Жомо Лха ри ཇོ་མོ་ལྷ་རི།

долооны өглөөний зоогийн цайны үед наран цагаан гэрэл цацруулсаар ургав. Зүүн зүгээс Гончиг хэмээх нэгэн ирж, мутрын авшиг айлтгав. Хоноглон саатсан тэр газар ч баруун хойд талдаа элдэв эрдэнээр чимсэн шүхэр босгосон мэт том уул буйн адагт хоёр талд нь хоёр алтан загас шүхэрлэн бэлд нь тулсан мэтийн уул нуруудын төв дунд эрдэнээр дүүргэн хэвлий нь бүлтийсэн сайхан цагаан болор хумх мэт нэгэн цагаан уул буй. Тэр уулын өмнө этгээдэд найман алтан дэлбээт лянхуагаар хүрээлүүлсний хүйсэнд үхэл үгүй²¹²-н рашаанаар дүүргэсэн мэт нуур, түүний нөгөө талд баруун эрчлээт номын цагаан лавайн дэлгэр хормой унжсан мэт уул ба, зүүн хийгээд зүүн өмнө найман хигээст хүрдэн, өлзийт цогт өлзий утсан хэлбэрт өлзий тодорхой уул ба, баруун өмнө элдэв эрдэнэ ачсан их заан лянхуат нуур уруу орсон мэтийн уулаар ордсон, огторгуйн найман хигээст хүрдэн түшлэгт, найман дэлбээт лянхуа мэт газар дэлхий тэргүүтэн сонин гайхамшигтай газар дэлхийгээр хүрээлүүлсэн, тэр мэтийн цомцог цагаан уулын оргилд залрахуйд эдийн тэнгэрийн зүг²¹³-ээс Буянтогтох, Бат-Очир хэмээх хоёр хүмүүн ирээд, мутрын авшиг айлтгав. Эдүгээ бээр ариусгалын зан үйл “Өлзий хутгийн хур буулгагч” айлдан соёрхож, тэр цомцог уулын хормой бэлд залрав. Шадарч нугууд лугаа сэлт “Аврал одуулахуй” ба “Шашин бадрахуй” тэргүүтнийг алгуурхан зарлиглаж, сайхан хэлбэртэй цагаан чулуу таалан аваад, сүм барихуй учир шалтгаантай газрын өр дунд битүүмж тэмдэг талбин зохиовой.

Тэнд анх ирсэн гурван хүмүүн бээр голлосон хар, шар олон хүмүүн цуглаад, олон өргөл лүгээ сэлт мандал өргөж, мутрын авшиг айлтгав. Шашин өнөд оршин тогтнохуйн бэлгэ дэмбэрэл нийцсэн мэт болохуйд таалал нь ихэд баясан цэнгэвэй. Тэгээд үд дунд болохуй үед нарны гэрэл түмэн шүхэр дэлгэсэн мэт бүлээн тод болохуйн үест лам, шавь цөм бүрнээр “Арван орны магтаал”²¹⁴ уншин, хоёр мутраа тэгш агуулан зохиохуй мөргөл, ламын лагшин насны бататгал ба, шашин дэлгэрэхийг адистидал! хэмээн сангийн зарлиг соёрхов.

Тэгээд дараа жилийн зуны тэргүүн сарын шинийн гурванд хийд орноо тогтоох тэр газарт гэр барих тэргүүтэн бэлтгэл базааж, багш, шавь нөхөр сэлт залрав. Арван тавны өдрөөс эртийн цай тогтоох бэлтгэл хангаж, арван тавны бүлээдэхүй цагт цагаан лавай гурвантаа үлээгээд, багш, шавь нугууд бээр өмнө талбисны үргэлжлэл “Их цаст уул Дэси”²¹⁵ хэмээх тэргүүтнээр эхийг хатгаад, аврал одуулахуй дэлгэр лүгээ ламын тахил ялгал үгүйг зарлиглаж, эртийн цайг тогтоон зохиожухуй. Тэр цагт,

“Чухаг дээд гурав нийт, Гэтэлгэгч дарь эхийн адистид

Чойжил номын хаан гурваар голлосон сахиусны хүчнээр

²¹² Үхэл үгүй - тэнгэрийн ёгт нэр

²¹³ Эдийн тэнгэрийн зүг нь умар зүг

²¹⁴ Арван орны магтаал གནས་བཅུ་འཕྲིན་པལ།

²¹⁵ Их цаст уул Дэси གངས་ཅི་ཆེན་པོ་ཉེ་ལ།

Чуулган хурлын Уулын бурсан хувраг өрнөн дэлгэрэхүй тив
Чухалчлан сансрын хязгаараа арвидан дэлгэрэхүй болтугай!

*Буян төгс бурсан хувраг арвидан дэлгэрэх энэ аймагт
Буяны ёсны шашныг баригч алтан уулан эрх мэт заларч
Буян төгс бурсан хуврагууд нь зуны нуур мэт арвидан
Буяны ёсны шашны лянхуан цэцэрлэг дэлгэрэх болтугай!*

Уулын буян төгстний бурсан хуврагийн арвидан дэлгэрэх тив
Улам цаашаа арвидаад, бурсан хуврагийн тариалан дэлгэрээд
Уламжлалт номлол, бүтээлийн шашны үйлс машид бадраад
Удирдагч ялгуусны шашин өнө удаан оршихуй болтугай!"

хэмээхүй үүнийг шинээр туурвин зохиожухуй.

Бас тэр өдөр Сэра, Врайбүн, Гандан гурвын ламаас дамжсан ядам, сахиус нугуудад залбирал талбиад, “Сэра, Врайбүн, Гандан гурвын Бэлгэ чанарын дацан сургуулийг энэ тогтоомуй” хэмээн лагшнаар наадахуй байдлаар бэлгэ дэмбэрэл зохион соёрхвой. Энэ үед:

“Бурхан бодисадва нийт хийгээд нэн ялангуяатайд
Бодисадва Насад Охилогчийн таалал үүтгэсэн хүчнээр
Бурсан хуврагийн энэ хийд орноо олдохуйяа машид бэрх
Билиг барамидын шашин өнө удаан бадрах болтугай!

*Билиг барамид арвидан дэлгэрсэн мөнхүү дацанд
Билиг барамидыг суралцан төгс хувьтнууд далай мэт арвижиж
Билиг барамидын номлол, сонсгол наран, саран хослон тодорч
Билиг барамидын шашны ой шугуй өнөд дэлгэрэх болтугай!*

Сэрэн дэлгэрсэн²¹⁶-ий агь хийгээд Насад охилогч
Самадийн хүчнээр билиг барамидын номлол, сонсгол
Саатан тогторлогч шулмын язгуурт бүхнийг амарлиулаад
Сайх билиг барамидын шашин өнө удаан дэлгэрэх болтугай!

*Билиг барамид арвидан дэлгэрсэн энэ дацанд
Бурсан хуврагийн чуулган зуны нуур мэт арвидаад
Бүтээл, номлолын шашны эрхэм үйлс нүгүүд
Бүтэн болохуй шинэдийн сар мэт дэлгэрэх болтугай!"*

хэмээсэн үүнийг шинээр туурвин зохиовой. Жич тэр жилд шашин оршихуй гурван суурийн үйлд бэрхшээл гарахыг болгоож, зан үйл, гарын авцыг ариутгахын үүднээс гурван суурийг нотод тогтоон зохиовой.

Тэр цагт ган гачиг, зуд турхан тэргүүтэн муу шалтгаан ямар мэт гарахаас болгоомжлон чухаг дээдэд нэгэн үзүүрт сэтгэлээр залбирал талбиж, хонин жил (1895)-д нэг дуган босгож, түүндээ Гэндэн Гэндүн Пэлжэйлин буюу

²¹⁶ Сэрэн дэлгэрсэн ལཱ་ལྷན་པ་ нь хоёр түйтгэрийн харанхуйгаас сэрэн, хоёр айлдварын гэгээнээр дэлгэрсэн бөгөөд бурхан

Уулын Буян төгс бурсан хувраг арвидан дэлгэрэх тив²¹⁷ хэмээх алдар соёрхов.

Хувилгаан ямагтын амрахуй орон ба бурсан хувраг тус, тусын хотол баясгалангийн хүрээ зарим нэгнийг бүтээсэн бээр тэр Хийдийн аймагт чухаг дээдийн тариалангийн бэлгэт алдар Очир суурин²¹⁸ алдар соёрхов. (Наран хутагтын цэдиг, 296-31a)

Тэгээд бичин жил (1896) хийд орондоо рид хувилгааны ерөөлийн хурал тогтоогоод, түгээл, цалин, цай тэргүүтнийг тогтоон зохиов. Түүний хойд тахиа жил (1897) Дээд банчин богдын хөрөг лагшныг урин залсан нэгэн Гаачин өөд болон морилоход, ал шарын жагсаалаар угтаж, тэр хөрөг лагшныг шүтээний голд залав. Ламын тахил лугаа барилдсан мандал өргөв. Тэр Гаачинд зоог хурим хийгээд тусгаарлан зооглуулах тэргүүтэн өргөл хүндлэл хянамгайлан зохиов. Нийт чуулган хурал хийгээд эртийн цайны лавай үлээх тэргүүтэн ба номын сахиусны эгшиг цэнгэлгээн нүүгүүдийг эмхлэн айлтган үйлдэж, үдэлтийн дагалтыг олон хүмүүн бээр зохиов.

Тэр цагт хийд аймаг ч алтан уулнаас наран мандсан мэт сүр жавхлантайяа үлэмж бадарсан гэдэг. Тэгээд нэгэн сүм байгуулж, алт зэсээр бүтээсэн Зуу Шагьяамүни бурхны хөрөг бүтээгээд залан соёрхов. Бас бурхан багш Чадагчийн эрхтийн алт зэсээр бүтээсэн нэгэн лагшин дутуу төдий байсныг өлзий хутгийн дэгжээн амаржуулагч бацаг, унжсан хэвлийтийн шугам татах тэргүүтнийг үйлдэж, үл үзэгдэхүй эзнээс газар авах тэргүүтнийг ёсчлон зохиогоод, Их дуганы бурхны өргөөг өргөнөөрөө хорин хоёр тохой, өндрөөрөө гучин дөрвөн тохой хэмжээтэй бүтээж, дээд өргөөний саравч ба дотор ханын зураг, үүдэн гэр, сэхээвч тэргүүтнийг маш сонин гайхамшигтай бүтээгээд, шүтээний эрхэм болгон өмнийн хөрөг лагшныг оршуулан соёрхож, **Түвданлхүнбэ** буюу **Чадагчийн шашны Сүмбэр уул**²¹⁹ хэмээх алдар олгов.

Тэгээд гучин долоон сүүдэр зооглосон гал гахай жил (1899) Дээд эзэн хааны зарлигаар Ховдын шар сүмийн хамбаар залран морилов.

Хамгийг айлдагч Дээрхийн гэгээнтнээс зарлиг бичиг, хамбын хэрэгсэл, дөрвөлжин тамга, **Самади**²²⁰ хэмээх цол соёрхов. Хамгийг айлдагч Банчинаас зарлиг бичиг, хамбын хэрэгсэл, дөрвөлжин тамга, **Хамба бандида**²²¹ хэмээх цол соёрхов. Хоёулаа ч шашинд аугаа их үйл зохих хэрэгтэй хэмээсэн гэгээний зарлиг буулган зохиохуйн үүдийг хянамгайлан соёрхов.

²¹⁷ Уулын Буян төгс бурсан хувраг арвидан дэлгэрэх тив དགེ་ལཱ་དགེ་འདུན་འཕེལ་བྱས་སྒྲིབ།

²¹⁸ Очир суурин རྫོག་གཏུག།

²¹⁹ Чадагчийн шашны Сүмбэр уул རྒྱལ་བཟུན་ལྷན་པོ།

²²⁰ Самади ས་མ་དྲི།

²²¹ Хамба бандида མཁའ་པ་སྒྲིབ།

Тэгээд Манзушир эзэн хааны шавранд шинэ жилийн өргөл хүндлэл үзүүлэхийг сонордуулан айлтгав. Туулай жил (1903) “Халхын Наран хутагт Дэчэн-Одсал шавран бээр өргөл хүндлэл айлтгах шалтгаанаар ирэх хэрэгтэй” хэмээсэн захидал зарлиг буусан бээр Их Бээжин хот уруу хөлгийн жолоо залав. Их эзэн хааны алтан гэгээнтэй золгоод, амар амгаланг нь айлтган мэндчилж, өлмий бататгалын гүрэм айлтган зохиосон бээр луун хээтэй бүхэл нолом торго, хув эрих тэргүүтэн хайр хишгийг хянамгайлан соёрхоод, эзэн хаан мэлмийгээр ихэд таалан зохиовой. Тэгээд сүмдээ жапү²²² хайрлах хэрэгтэй хэмээн айлтгасан бээр Дэндоглин²²³ буюу Үнэнийг оногч тив адил үгүй гурван үсгийн зэбан²²⁴-гаар алдар соёрхов. Тэгээд Хуандигийн жаран насны баяр хуримд есөн цагааны бэлэг өргөв.

Бор жолоо, цулбуур, Нангиад хоёр үсэгт өлзийт бичиг, зандан модоор урлан, хас хээгээр хээлсэн аяга тэргүүтэн хайр хишиг хянамгайлан хайрлав. Тэгээд “Шавь хуврагуудыг захирах тамга хэрэгтэй” хэмээн сонорын хуурцагт өргөсөн бээр **“Наран хутагтын албатуудаа захирах тамга”** хэмээхүй гурван зүйл үсгээр бэлгэдсэн мөнгөн тамга соёрхов.

Бус бас Дээд эзэн хааны өлмий бататгалыг бүтээхүй ба шашинд тустай ёсыг сонорын хуурцагт айлтгасан бээр шунхан бичгээр “Би бээр айлдан зарлиглаж, үнэн зүрхнээсээ анхаармуй” хэмээн таалан зохиов.

Тэр үест Цастны зүгт элч тусгайлан илгээн мэдэгдэж, Лхасын ерөөлийн хуралд хуврагийн цай өргүүлэв. Дээд ялгуусан хотлыг болгоогчид мандал өргүүлсэн бээр Чадагчийн эрхтийн лагшин хөрөг, дээд зайн хэсэг сэлтийг соёрхов. Хамгийг болгоогч Банчин гэгээнд мандал өргүүлсэн бээр Ра хэвийн Очир Аюулгагч, эд зайн хэсэг сэлтийг соёрхов. Сажа банчинд мандал өргүүлэхэд тэргүүний малгайгаа авсан Богд ламын лагшин хөрөг соёрхов.

Вамо номын сахиулсан²²⁵-д шашныг сахихуй аврал айлтгуулахад сахин тэтгэхийг гэгээнээр таалан зохиож, мутрын тэмдэг илд хайрлажээ. Найчүн номыг тэтгэгч²²⁶-д аврал айлтгуулахад, “Би үйлсийг тань үйлдэнэ” хэмээгээд, мутрын тэмдэг илд хайрлажээ.

Самлогийн Тангарагтан²²⁷-д аврал айлтгахад, “Тэр лам нь миний ачит язгуурын лам мөн” хэмээн дахин дахин зарлиглав. “Миний ачит язгуурын ринбүүчигийн дэргэд түргэнээ залартугай!” хэмээн зарлиглаж, зүрхэн тус газар

²²² жапү རྩུལ།

²²³ Дэндоглин བདེན་རྟོགས་ལྷིང་།

²²⁴ зэбан ཙེ་བན།

²²⁵ Вамо номын сахиулсан བ་མོ་ཚས་སྦྱང་།

²²⁶ Найчүн номыг тэтгэгч གནས་རྒྱང་ཚས་སྦྱང་།

²²⁷ Самлогийн Тангарагтан བསམ་ལྷོ་འི་དམ་ཅན།

зүүсэн хоёр талт маш тунгалаг тод толь тайлан өргүүлэхээр илгээснээ ордож, олон эрхэм дээдсээс дуурайн илгээхүйг маш ихээр зохиовой.

Бус бас нэг жилийн рид хувилгааны ерөөл тайлсан арван зургааны эртийн цайны эхэнд Их дуганы Чадагчийн шашны Сүмбэрийн өмнө этгээдийн дээд давхарт Гомбын аймгийн сахиулсан гадна, дотно, нууц гурван номын хааны өмнө эртнээс нягтлан бичин зохиосон Лувсангийн буман зарлигийг оршуулан соёрхож, гурван зүйл Номын хаанд Хоёрдугаар ялгуусны нийт шашин ба нэн ялгамжтай зарлигийг чухалчлан даатган зохиовой.

Тэр цагт эртийн цайны чуулган хурал уншив. Намрын сард бэлгэ дэмбэрлийн хурим хийхүй лүгээ цаг нэгнээ тохиож, түүнд залран ирэхүйд өмнө зүгээс машид үзэсгэлэнтэй цагаан үүл гараад, тэр даруйд үймэлзэн үелзэн ойртон ойртон ирэхийн үед

“Цогт их амгалан номын тод дуртмал лагшнаа
Цойлсон богд Сайн оюутын зүрхэн тус газраас
Цугласан хөвөн цагаан үүлсийн үзүүрт Вэнсагийн богд
Чухамхүү энэрэхүйн хүчний эрхээр энд саатан соёрх оо!

Таалалт богд Хоёрдугаар ялгуусан ямагт лугаа
Таалал нь нэгнээ хурсан Вэнсагийн богд ламтан
Та нар минь үндсийг минь адистидлахын тул
Таалан насад хагацал үгүй тавтай морилон сааттугай!

Эцэг Вэнсагийн *Сайн оюут тус бүтээгч*²²⁸ гэгээнтэн
Эгэл хөвгүүн намайг энхрийлэхүй ачаа санахыг
Эгшиг цаг бүхнээ элэг зүрхний угаас залбирал талбия
Энэ сэтгэлийн үндсийг минь адистидлан хайрлааа!

Хаан язгуурын тэнгэрийн хувьт Вэнсагийн эрхэм
Халуун итгэлт та бээр гэгээний үзэгдлээ эс хагацаагаад
Хамгаас гүнзгий аугаа их зарлиг увдисаар тэтгэ!
Хамаг таалал бүтээлээрээ баясган адислан хайрла!

Нэгэн насандаа бурхан болсон Вэнса гэгээнтэн
Нигүүлсэн өршөөгч богд таны зарлигийн ачаар
Мөрийн хоосон чанарын энэрэхүйн зүрхийг амсаж
Мөнхүү хоёрдугаар бодисадвагийн хутаг олохыг адистидал!

Алдар тань их амгалангийн цэнгэлгээнт Очирдарь
Алин таны лагшин, зарлиг, тааллын гэрлээр
Анхааран амгалан, хоосон чанарыг ялгамжтай онол
Алаг зүрхний голд бадрахыг адистидлан хайрла!

Цогт тод гэрлийн номын лагшны хүрдэнд
Цогтой богд таны таалал лугаа миний сэтгэл

²²⁸ Ташуугаар бичсэн *Сайн оюут тус бүтээгч* нь төвөдөөр Лувсандондов *ལུང་བཟང་འཕྲུལ་*

Цаг мөч бүхнээ мөн чанар ялгалгүй болон

Цаашдаа нэгэн чанарт болон холилдохыг зохион соёрх!”

хэмээсэн зарлиг зохиовой.

Тэрхүү цагаан үүл ч үймцэн үелзэн оршихуйд шадарч нугууд бээр “Энэ цагаан үүл ердийн үүл лүгээ адилгүй үзэгдэж буй нь ямар сайхан учир шалтгаантай байнам?” хэмээн айлтгахад “Ямар мэт болохыг эс мэднэм, хэдий тийм боловч сайн чуулган тахилыг бэлтгэ!” хэмээн зарлиглав. Чингээд тахил хийгээд чуулган тахилыг түргэн бэлтгэсэн бээр мөнхүү богдын өөрийн гэгээнээс гагцхан агшин өнгөрөхүй лүгээ гурван адистидыг зарлиглаж, чуулган тахилын зан үйлийг ч эс зарлиглахуйд,

“Эгц дээд Дүштийн тэнгэрийн оройн чимэг

Эцэг Зөөлөн цогтын тааллын гол дундаас

Эзэн богд Вэнса *Оюун сайт тус бүтээгч*²²⁹ алдартан

Энэрэн өршөөхүйн эрхээр энд ажран соёрх оо!

Өөрийн минь өмнө лянхуа, саран дэвсгэрт арслант ширээнээ

Өнчрөн хоцорсон хөвгүүн минийхээ буяны дээд тариаланд

Өмөг түшиг болсон эцэг та сонорын дамжлагыг бүтээхийн тулд

Өршөөн таалаад өнөд баясаад батад оршин хайрла аа!

Таалал нь хамтад төрсөн их амгалангийн чанар лугаа

Таатайяа гүнзгий зарлиг, нууц номын хуримыг үйлд

Таван солонгон биеийн ал шарын үзэсгэлэнт дуазыг

Тамир муутай би үзэн, сонсон, дурссанаар үргэлжид сөгдмүй.

Орон тариалан бүхнийг тахилаар дүүргэн тахья

Онцгойлон бие, хэл, сэтгэл гурваар цавдан өргөө

Оройн дээд итгэл ээ тааллаараа барин соёрх оо!

Төрвөл үгүй цагаас хураасан хилэнц түйтгэр ба

Тухайлан энэ насанд авсан чухал гурван санваарын

Цааз зарчим лугаа харшилсан гэм эрүү бүхнийг

Цаглашгүй итгэлт таны өмнө чин сэтгэлээр наманчилъя!

Нийтэд гурван цагт залран өөд болсон хутагтууд ба

Нэн ялгамжлахуйд итгэл эцэг та энэ гагц насандаа

Ариусан гэгээрч бурхан болсон гайхамшигтай цадигт

Адаг доорд хөвгүүн би чинь даган баясан үйлдье ээ!

Өршөөн нигүүлсэхүйт итгэл багширсан усан баригч²³⁰-аасаа

Өөрийн минь үндэсний сүсгийн тариалан газар шороонд

Үнэхээр сайн анхаарал онолын лянхуан цэцэрлэгийг дэлгэрүүлэх

Үзүүлэгч бурхны гүнзгий дэлгэр номын хурыг буулган соёрх!

²²⁹ Ташуугаар бичсэн *Оюун сайт тус бүтээгч* нь төвөдөөр Лувсандондов *ལྷ་བཟང་དྲན་གྱུབ།*

²³⁰ Усан баригч - үүлний ёгт нэр

Цаашид үүгээр жишсэн буяны сайн чуулган нугуудаар
 Цаглашгүй итгэл Вэнсагийн богд таны соёрхолд
 Цаг насад хэзээ ч хагацалгүй даган баригдаж
 Цатган тэжээгч сонорын дамжлагыг тань насад амсах болтугай!
 Эцэг *аглаг газрын Оюун сайт тус бүтээгч*²³¹ богд
 Энхрий үр миний оройд батад морилон саатаж
 Энэрэн нигүүлсэхүй их өршөөлөөр дагуулан эзлэн бариад
 Эчнээ нууц гурвын шид бүтээл өршөөн соёрх оо!
 Үнэнхүү зам мөрийг номлон зохиогч язгуурын лам
 Үнэнхүү судар тарнийг заагч Чадагчийн эрхт Очирдарь
 Үнэнхүү амгалан, нууц, аюулгагч бурхан *Сайн оюутад*
*алдаршсан*²³²

Үнэнхүү Вэнсагийн их богд нугуудад залбирал талбия!
 Эцэг *аглаг газрын Оюун сайт тус бүтээгч* богд
 Энхрий үр миний оройд батад морилон саатаж
 Энэрэн нигүүлсэхүй их өршөөлөөр дагуулан эзлэн бариад
 Эчнээ нууц гурвын шид бүтээл өршөөн соёрх оо!”
 хэмээсэн энэ зарлигийг зохиосон бээр “Эгц дээд Дүштийн тэнгэрт эх”²³³
 хэмээгч үүнийг эртийн цайны уншлага болгон тогтоожухуй (Наран хутагтын
 цадиг, 34а-35б).

Бус бас завсрын зарим нэгэн он жилүүдэд Риво Гэндэн
 Гэндүнпэлжэйлинд байнгын чуулган хурлын эртийн цай, дөрвөн их сайн
 цагийн ерөөл, Гандангийн тавны их тахил²³⁴, Эзэн хааны их гүрэм нүгүүдийг
 мөнхийн болгон тогтоогоод, Бэлгэ чанарын дацан Шэрчинпэлжээлин²³⁵,
 Жүдийн дацан Дэчэнвар Жүд²³⁶ нүгүүдийг тогтоон зохиовой.

Тэгээд лагшин сүүдэр тавин дөрөв (1916)-ийн дээр “Төгс цогт язгуурын
 ламд шүтсэн мөрийн зүрхэн”²³⁷ хэмээгдэх шастирын анхдугаар бүлгийг зарлиг
 туурвил зохиов.

Тавин таван сүүдрийн үест (1917) тэр шастирын номлолд дулдуйдан
 жишвээс хоёрдугаар бүлгээс дээших нь дээр үгүй нууц тарнийн шимийг мухарт
 нь хүртэл бичсэн харагддаг ажээ. Тэр мэт болбоос эчнээ дуурьсгахуй нь гэм

²³¹ *аглаг газрын Оюун сайт тус бүтээгч* *ᠠᠭᠯᠠᠭ ᠭᠠᠰᠢᠷᠠᠨ ᠣᠶᠤᠨ ᠰᠠᠶᠢᠲᠤ ᠲᠤᠰ ᠪᠦᠳᠡᠭᠴᠢ* Вэнса Лувсандондов

²³² *Сайн оюутад алдаршсан* *ᠰᠠᠶᠢᠨ ᠣᠶᠤᠲᠤ ᠠᠯᠳᠠᠷᠰᠠᠨ* Лувсандамба

²³³ Эгц дээд Дүштийн тэнгэрт эх *ᠡᠭᠴᠢ ᠳᠡᠭᠡᠳᠡ ᠳᠦᠰᠡᠳᠡᠨ ᠲᠡᠩᠭᠡᠷᠲᠡ ᠡᠬᠡ* *ᠰᠡᠭᠡᠳᠡᠨ ᠳᠦᠰᠡᠳᠡᠨ*

²³⁴ тавны тахил *ᠲᠠᠬᠢᠯ* Монголын улирлын тооллын аравдугаар сарын хорин таван буюу Зонхаба
 богдын таалал төгссөн өдөр өргөх тахил, эл өдрийн орой зул өргөдөг заншил Шар малгайтны
 шашинтнуудад түгээмэл тогтсон заншил билээ.

²³⁵ Шэрчинпэлжээлин *ᠰᠡᠷᠴᠢᠨᠭᠢᠨᠯᠡᠭᠡᠯᠢᠨ* *ᠰᠡᠷᠴᠢᠨᠭᠢᠨᠯᠡᠭᠡᠯᠢᠨ*

²³⁶ Дэчэнвар Жүд *ᠳᠡᠴᠡᠨᠪᠠᠷ ᠵᠦᠳᠤ*

²³⁷ Төгс цогт язгуурын ламд шүтсэн мөрийн зүрхэн *ᠲᠡᠭᠦᠰ ᠴᠣᠭᠲᠤ ᠵᠠᠭᠭᠠᠷᠠᠨ ᠯᠠᠮᠳᠤ ᠰᠡᠭᠡᠳᠡᠨ ᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠵᠦᠷᠬᠡᠨ* *ᠳᠡᠭᠦᠰ ᠴᠣᠭᠲᠤ ᠵᠠᠭᠭᠠᠷᠠᠨ ᠯᠠᠮᠳᠤ ᠰᠡᠭᠡᠳᠡᠨ ᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠵᠦᠷᠬᠡᠨ*

алдал эс болно хэмээн бодохуй таалал ургасан ч судар, тарни хоёулын мөрийг гүйцээсэн энэ ламын ёгыг гүйцээхэд лам тааллаа төгсгөн, их хүчир өвчний эвэршээл болсон тул “Хэрэгтэйг голлон барих хэрэгтэй” хэмээн таалаад, зарлиг туурвилын дотор буй нь энэ ээ. Энэ ламын зарлиг туурвил нь дөрөв, тав орчим боть бөгөөд бүгдээрээ шүлэглэсэн гүн гүнзгий утгатай зохист аялгуун туурвил бөгөөд харшилсан хийгээд эс барилдан няцсан тэргүүтэн гэм огт үгүй, дээд, дунд, доорд гурван оюунтанд ач тус ихтэй, Ялгуусан вэнсагийн эцэг, агийн эрхэм сайн зарлиг лугаа утга таацсан, эш хийгээд ухаанаар шинжлэн мэдвээс хамаг судар, тарнийн оньсыг хураасан байдаг билээ хэмээн эл хутагтын цадиг бичигч онцгойлон тэмдэглэсэн байдаг.


3. Дүгнэлт

Үйлийн үрийн сургаал номлолын ёсоор үйлдсэн үйл үл хоосрохуйн үргэлжлэл болсон, Монголын хаадын улс, төр шашны улбаат хутагт хувилгаадыг тодруулах хийгээд тэдний зохиол үйлсийг судлан эдүгээ сайн цагийн ачаар шашин, номоо хүндлэх болсон үед өмнийн хутагт хувилгаадыг тодруулан тэдний үйлс зохионгуйг уламжлал ёсоор үргэлжлүүлэх нь даяарлын үед ондоошиж даяар олноо тус хэрэгтэй болох нь дамжиггүй ээ.

Үнэн худлыг мэдэхгүй олон лам нарын хувилгаан хэмээгч алдартай мэдээтэй, мэдээгүй нүгүүд тодорч, нэгэн баян хүмүүний үүргэч мэт харагдах нь огт зохисгүй бөгөөд ном эрдэмд нэвтэрч, ноттойяа шидийг үзүүлэн, нийт олны тусын тулд үйлс зохионгуйгаа зориулдаг өмнийн уламжлалыг өдгөө цагийн өндөр боловсролтой өргөн олноо таниулан таалах таатай цагийг миний мэт мөхсүүд хүлээн ширтэн суугаагаа хэлэх нь илүүц буй заа.

Ном зүй

- Тэрбиш, Л.** (2024). *Ханчин чойжил Лувсанцэвээнжавчогбалсамбуугийн цадиг*. Төвөд хэлнээс орчуулж тайлбар хийсэн Л.Тэрбиш. Улаанбаатар. [L.Terbish. *Hanchin choijil Luvsantseveenjavchogbalsambuugyn tsadig*. Tovod helnees tailbar hiisen L.Terbish. [*Biography of Hanchin choijil Luvsantseveenjavchogbalsambuu*. Translated from tibetan L.Terbish]
- Лувсанпэрэнлэй.** *Заяын Сан-Ег*. Дөрөвдүгээр боть. [Zayaun san-yig. Dorovdug eer boti.]
- Наран хутагтын цадиг.** *Цогт Вэнсаба ёсны сонорын дамжлагын шашны эрхт эзэн Наран хутагт Дэчэн-Одсалбалсамбуугийн цадигийг товчхон төдий өгүүлсэн сонин гайхамшигт сүсгийн гэгээ хэмээгдэх оршвой*. [tsogt vensaba yosny sonoryn damjlagyn shashny erht ezen Naran hutagt Dechen-Odsalbalsambuugyn tsedigyg товчхон todii uguulsen sonin gaihamshigt susgiin geg ee hemeegdeh orshvoi]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.